



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

“ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ТАВ” ОНӨААТҮГ

Нийслэлийн засаг захиргааны II байр,
Ц.Жигжиджавын 7 дугаар гудамж,
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160
Утас: (976) 7007 7071
Цахим шуудан: 5.zteever@gmail.com

2024.08.26 № 01/82
танай _____-ны № _____-т

Төсөл арга хэмжээний тухай

Нийслэлийн “ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ТАВ” ОНӨААТҮГ-аас зарласан ЗТТ/20240200102 дугаартай Шатахуун худалдан авах тендерт оролцогчоос ирүүлсэн тодруулгад дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

Асуулт 1: Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөц шаардсан байна. 6-н ээлжийн түгээгч нь Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ-ын аль аль бааз дээр ямар хуваариар ажиллах талаар мэдээлэл өгнө үү?

Хариулт 1: Тендерийн баримт бичигт барааг дагалдах хүний нөөц буюу нийт 6 түгээгч шаардсан ба уг ажилтнууд нь БГД-ийн 20 дугаар хороо үйлдвэрийн баруун бүс-1 ХД байрлах Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ-ын 1 дүгээр баазын ШТС-д, БЗД-ийн 8 дугаар хороо, Улаанхуаран С.Данзангийн гудамж 37/3 тоот Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ-ын 2 дугаар баазын зөөврийн ШТС-д, СБД 14 дугаар хороо Дамбадаржаагийн гудамж 9 тоот байрлах Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ-ын 3 дугаар баазын ШТС-д, СХД-ийн 33 дугаар хороо Тахилтын 6 дугаар гудамж 1 тоот хаягт байрлах 4 дүгээр баазын зөөврийн ШТС гэсэн 4 байршилд Хөдөлмөрийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.2 дахь хэсэгт заасны дагуу ажлын өдрийн үргэлжлэл 8 цаг байна.

Асуулт 2: Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага хэсгийн 2-р хэсэгт "Шаардлагатай тохиолдолд Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ-ын авто баазуудад зөөврийн ШТС байрлуулж түгээгчээр хангаж ажиллах" гэсэн заалт байна. Уг шаардлагын хувьд танай хэдэн баазад зөөврийн ШТС байршуулах вэ? Зөөврийн ШТС байршуулсан тохиолдолд манайхаас хэдэн түгээгч нэмж ажиллуулах шаардлагатай вэ?

Хариулт 2: БЗД-ийн 8-р хороо, Улаанхуаран С.Данзангийн гудамж 37/3 тоот Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ-ын 2 дугаар баазын зөөврийн ШТС, СХД-ийн 33-р хороо, Тахилтын 6 дугаар гудамж 1 тоот хаягт байрлах 4 дүгээр баазад зөөврийн ШТС тус тус байрлуулна. Дээр дурдсан хүний нөөц дээр нэмж түгээгч ажиллуулж болно.

ЗАХИРАЛ



С.БАТЗАЯА